



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс: (976-11) 32-06-68

2018.12.17 № 32/4185
танай _____-ны № _____-т

ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬД

“Үнэт, ховор ном, гар бичмэл”
үзэсгэлэн, семинар -2018-д
оролцох урилга хүргүүлэх тухай

МУИС-ийн номын сангийн сан хөмрөгийг үнэт, ховор ном, гар бичмэлээр баяжуулах, ховор ном, гар бичмэлийн мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор МУИС-ийн номын сангаас эрхлэн “ҮНЭТ, ХОВОР НОМ, ГАР БИЧМЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН, СЕМИНАР-2018” сэдэвт цуврал үйл ажиллагааг зохион байгуулах гэж байна.

Энэ ажлын үндсэн зорилт нь Монголын номын сангуудын сан хөмрөгт болон хувь хүнд хадгалагдаж байгаа шинжлэх ухааны бүх салбарын агуулга бүхий үнэт, ховор ном, гар бичмэл материалын судалгаа хийх; МУИС-ийн номын санд үнэт, ховор ном, гар бичмэл материалын өвийг төвлөрүүлэх боломжийг хайх; Байгууллага болон хувь хүний эзэмшилд байгаа үнэт, ховор ном, гар бичмэл материалын байршлыг МУИС-ийн номын сангийн электрон каталогитой холбох замаар баримтат өвийн мэдээллийн сан үүсгэх, эргэлтэд оруулах, нийтэд сурталчлах, хадгалалт хамгаалалтыг сайжруулахад оршино.

Энэ удаагийн “Үнэт, ховор ном, гар бичмэлийн үзэсгэлэн, семинар-2018” үйл ажиллагаа 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагт МУИС-ийн номын санд зохион байгуулагдах гэж байна.

Танай номын сан болон Таныг “Үнэт, ховор ном, гар бичмэл” сэдвээр илтгэл тавих, үзэсгэлэнд үнэт ховор ном, гар бичмэлээ тавих, хандивлах, санал бодлоо солилцох зэргээр оролцохыг урьж байна.

Манай үйл ажиллагаанд идэвхтэй оролцоноор өөрт байгаа соёлын үнэт өвөө нийтэд таниулах, судалгааны эргэлтэд оруулах, харилцан мэдээлэл солилцох, нийгмийг соён гэгээрүүлэх, үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулах болно.

Оролцох байгууллага, хувь хүн та 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор бидэнтэй холбогдож бүртгүүлнэ үү.

Имэйл хаяг: library@num.edu.mn

Холбогдох утас: 75754400-1411, 99064401, 89139424, 91991076

НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ



Г.ЦЭРЭН /Ph.D/